| **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **469,902,823.77** | **167,207,053.02** | **1,034,802,990.68** | 1,671,912,867.47 |
| **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **469,902,823.77** | **167,207,053.02** | **1,034,802,990.68** | 1,671,912,867.47 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **469,902,823.77** | **167,207,053.02** | **1,034,802,990.68** | 1,671,912,867.47 |
| Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 177,992,793.38 | 177,992,793.38 |
| **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **469,902,823.77** | **167,207,053.02** | **1,212,795,784.06** | 1,849,905,660.85 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 813,207,700.00 | 812,036,683.41 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 813,207,700.00 | 812,036,683.41 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 756,058,300.00 | 754,906,124.91 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 506,568,400.00 | 506,365,807.72 |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 302,163,100.00 | 301,976,995.68 |
| 210102 | Нэмэгдэл | 171,196,500.00 | 171,180,062.04 |
| 210104 | Урамшуулал | 33,208,800.00 | 33,208,750.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 61,709,600.00 | 61,119,156.05 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,098,500.00 | 43,022,733.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,064,600.00 | 5,061,498.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,532,400.00 | 2,530,749.01 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,203,000.00 | 2,100,834.73 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,811,100.00 | 8,403,340.92 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,304,300.00 | 26,294,239.34 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,626,500.00 | 2,616,566.84 |
| 210302 | Түлш, халаалт | 23,542,300.00 | 23,542,172.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 135,500.00 | 135,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,508,400.00 | 28,500,150.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,234,700.00 | 3,234,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,272,500.00 | 20,264,750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,036,300.00 | 3,036,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 100,000.00 | 100,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,864,900.00 | 1,864,450.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,045,000.00 | 1,045,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,045,000.00 | 1,045,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 14,467,400.00 | 14,467,396.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,980,000.00 | 3,980,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,487,400.00 | 10,487,396.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 23,814,000.00 | 23,474,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 23,814,000.00 | 23,474,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 44,200,100.00 | 44,199,838.60 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 41,656,000.00 | 41,656,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 823,100.00 | 823,050.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 593,600.00 | 593,497.60 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99,500.00 | 99,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 440,000.00 | 440,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 587,900.00 | 587,791.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 49,441,100.00 | 49,440,537.20 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 48,941,100.00 | 48,940,537.20 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.00 | 500,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 57,149,400.00 | 57,130,558.50 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 57,149,400.00 | 57,130,558.50 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 2,500,000.00 | 2,500,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 7,507,500.00 | 7,488,700.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 45,141,900.00 | 45,141,858.50 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 813,207,700.00 | 812,036,683.41 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 811,207,700.00 | 808,670,256.81 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 811,207,700.00 | 808,670,256.81 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 2,000,000.00 | 3,366,426.60 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,000,000.00 | 3,366,426.60 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | - | **43,271,244.96** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | - | **38,977,659.65** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 38,977,659.65 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | 7,233,825.65 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | 7,233,825.65 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 2,926,750.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 464,750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 400,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 2,062,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 1,603,700.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 1,603,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 2,495,684.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 2,495,684.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 24,717,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 24,717,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | **4,293,585.31** |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | - | 4,293,585.31 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | **43,271,244.96** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | **43,271,244.96** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 2,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 28,409,904.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 12,861,340.96 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

**3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газар нь төрийн үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг, Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Тухайн байгууллага эрхэм зорилгоо "Төрийн үйлчилгээний шуурхай байдал, чанар хүртээмжийг сайжруулж, өрхийн амьжиргааны чадавхыг дээшлүүлэх хүний хөгжлийг бүх талаар хангах замаар орон нутгийн тогтвортой хөгжлийг хангана." гэж тодорхойлжээ.

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Байгууллагын үйл ажиллагаанд мөрддөг хуулиудад өөрчлөлт ороогүй. Харин төрийн албан хаагчдын цалин хөлстэй холбоотой Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоолыг хэрэгжүүлж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь дотоод аудитын нэгжгүй, дотоод аудитыг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хийдэг, тус онд хяналт, шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар "Ангилал шинэчлэн батлах тухай", 229 дугаар тушаалаар "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг 2024 оны 01 дүгээр сараас дагаж мөрдөхөөр баталсан. Гэвч тус онд санхүүгийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн хийгдэж дуусаагүйтэй холбоотой дээрх журмууд хэрэгжээгүй байна.

Иймд Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 188,611.3 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 1,729.8 | 2,534.8 | 805.0 |
| Авлага | 715.4 | 3,082.1 | 2,366.7 |
| Бараа материал | 198,826.5 | 215,559.7 | 16,733.2 |
| Нөөцийн бараа | | | - |
| Үндсэн хөрөнгө | 1,471,152.3 | 1,639,858.7 | 168,706.4 |
| **Нийт хөрөнгө** | **1,672,424.0** | **1,861,035.3** | **188,611.3** |
| Өр төлбөр | 511.2 | 11,129.7 | 10,618.5 |
| Засгийн газрын хувь оролцоо | 1,671,912.8 | 1,849,905.6 | 177,992.8 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө** | **1,672,424.0** | **1,861,035.3** | **188,611.3** |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,534.8 мянган төгрөг болж 805.0 мянган төгрөгөөр өссөн нь ахмадын сангийн үлдэгдэл байна.

Тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан 431,601.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 27,748.8 мянган төгрөгийн бараа материалыг хүлээн авч бүртгэл, тайланд тусгажээ. Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 168,706.4 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөгжлийн сангаас малын угаалгын банн болон универсал трактор хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна. Бараа материалын данс тайлант оны худалдан авалтаас шалтгаалж 16,733.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Сумын эмийн эргэлтийн сан ОНӨААТҮГ-уудыг татан буулгах тухай" 16 дугаар тогтоолын дагуу 3,082.1 мянган төгрөгийн авлага, 11,120.9 мянган төгрөгийн өглөг, 12,163.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 8,446.3 мянган төгрөгийн бараа материал, 10.0 мянган төгрөгийг харилцах дансны үлдэгдлийг тус тус бүртгэж авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,849,905.6 мянган төгрөг болж 177,992.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 687,600.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 78,507.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 766,107.4 мянган төгрөгөөр батлагдсаныг төсвийн жилийн дундуур 47,100.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт 813,207.7 мянган төгрөг болгон тодотгосон байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 813,207.7 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Төсвийн жилийн дундуур тодотгосон нь ЗГ-ын "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай " 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалинг нэмсэнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэлийг 812,036.6 мянган төгрөг буюу 99.8 хувьтай зарцуулж, 2,537.4 мянган төгрөгийг буцаан орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ. Өөрийн орлогын төлөвлөгөөг 1,366.4 мянган төгрөгөөр давуулан биелүүлж орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 99.8 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх шимтгэл, албан томилолтын зардлыг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Аудитаар бараа үйлчилгээний бусад зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардалтай холбоотой алдаа, зөрчил илрээгүй.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл* /мянган төгрөгөөр/

| Хөтөлбөр, арга хэмжээ | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|
| 80101[1] | 596,295.6 | 595,288.9 | 1,006.7 | 99.8 |
| 80106[2] | 121,921.6 | 121,776.6 | 145.0 | 99.9 |
| 80714[3] | 2,500.0 | 2,500.0 | - | 100.0 |
| 80801[4] | 7,507.5 | 7,488.7 | 18.8 | 99.7 |
| 80802[5] | 47,141.9 | 47,141.9 | - | 100 |
| 81102[6] | 32,741.1 | 32,740.5 | 0.6 | 100 |
| 82212[7] | 100.0 | 100.0 | - | 100.0 |
| 82801[8] | 5,000.0 | 5,000.0 | - | 100.0 |
| **70106** | **813,207.7** | **812,036.6** | **1,171.1** | **99.8** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

[1] Үндсэн үйл ажиллагааны зардал
[2] Баг хорооны үйл ажиллагаа
[3] Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт
[4] Нөхөн олговор

[5] Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал
[6] Орон нутгийн нөөц хөрөнгө
[7] Хог хаягдал цэвэрлэх үйлчилгээ
[8] Улсын их баяр наадам

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 28,409.9 мянга, Эхлэл ургац энержи ХХК-аас нийгмийн хариуцлагын хүрээнд хандиваар 2,000.0 мянга, үндсэн үйл ажиллагаанаас 12,861.3 мянган орлогыг тус тус бүрдүүлжээ. Тус зардлын дийлэнх хувийг худгийн зардал, жилийн эцсийн мал тооллоготой холбоотой зардал, мал эмнэлгийн үйлчилгээний зардал, байгалийн гамшгийг бууруулах зардалд зарцуулж, үлдэгдэл 4,293.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "*Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана*" заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын Ахлах аудитор Т.Батсайхан гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Т.Оюун-Эрдэнэ, газрын дарга, Тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн санхүү үр дүнгийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг санхүү, үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,039,673.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 10,369.7 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг түвшнийг шинэчлэн тогтоогүй болно.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 32 горим сорилыг төлөвлөж, хэрэгжүүлэхэд Цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй этгээдээс тоног төхөөрөмж худалдан авсан зөрчил илэрсэн. Нийт батлагдсан төсвийн 99.8 хувийг зарцуулж, 2,537.4 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгож орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ. Хэмнэлтийн дийлэнх хувь нь зардлын хэмнэлт байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 4 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 онд нийт 812,036.6 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулж, хуулийн хэрэгжилт 100.0 хувьтай байсан.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 400.0 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлснийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 500.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа илэрснээс албан шаардлага, төлбөрийн актын биелэлт 100 хувьтай хэрэгжсэн байна.

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 500.0 | 1 | 500 | 100.0 |
| Албан шаардлага | 4 | - | 4 | - | 100.0 |
| Хариуцлага тооцох албан шаардлага | 1 | - | 1 | - | 100.0 |
| **Нийт дүн** | **6** | **500.0** | **6** | **500.0** | **100.0** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан дараагийн аудитаар тээвэр шатахууны тооцоололд биет горимыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,380.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс авлагатай холбоотой 400.0 мянган төгрөгийн, цахим худалдан авалттай холбоотой 3,980.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага тус тус хүргүүллээ.

### 5.1 Албан шаардлага

- Харилцагч байгууллагатай 400.0 мянган төгрөгийг авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй. Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д /*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;*/, мөн хуулийн 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/, заасныг;
- Цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй этгээдээс 3.980.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 38 дугээр зүйлийн 38.1-т */Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна/*, 38.5-д */Цахим дэлгүүрт нэг гүйцэтгэгч байгаа, эсхүл үнийн санал дуудахад үнийн санал ирээгүй бол захиалагч цахим дэлгүүрт бүртгэгдсэн хамгийн бага үнийн санал бүхий бараа, үйлчилгээг худалдан авч болно/*, Төрийн хэмнэлтийн хуулийн 14 дүгээр зүйл 14.4-т */Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно/* заасныг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:Харилцагч байгууллагатай авлагын тооцоо нийлж, баталгаажуулах, барагдуулах, цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулсан этгээдээс авч хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Авлагын үлдэгдлийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй. | 1 | 400.0 | - | - | 1 | 400.0 | - | - | - | - |
| **Дүн** | **1** | **400.0** | **-** | **-** | **1** | **400.0** | **-** | **--** | **-** | **-** |

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй этгээдээс тоног төхөөрөмж худалдан авсан. | 1 | 3,980.0 | - | - | 1 | 3,980.0 | - | - | - | - | - | - |
| Дүн | 1 | 3,980.0 | - | - | 1 | 3,980.0 | - | - | - | - | - | - |